

## ЭРТНИЙ САЙХАН ХЭМЭЭХ ДУУНЫ ТУХАЙ

Д.Баасанжав

Эртний сайхан ерөөлөөр

Энэ Монгол орондоо

Эзэн Чингис хааны үрс нь болж

Хувьтайхан төрсөн ах дүү та нар минь уу зээ хэмээх энэ дууны үг ая аялгуу нь Монгол хүний зүрх сэтгэлийг хаа нэгтээ сансар огторгуйн гүнээс ч юм уу, далдын далдаас даллан дуудах өндөр их өвгөдийнхөн шившлэг тарина био энергийн нууц хүч хөх тэнгэрийн дуудлага мэт олон олон жаран зууны турш амь бөхтэй ирсэн нь утга агуулга гүн хол ч, ая эгшиг нь бадрангуй цог хийморлого мөхөшгүй мөнхийн итгэл билэгдэл төгс байдгаас л хөрш залгаа улс гүрний хөндүүр, газрын өргөс мэт болдогоос Монголчуудын эх оронч санаа сэтгэлийг нухчин дарах эхний ээлжинд ард түмний соёл урлаг, дуу хөгжим, бүжиг туульс ялангуяа уртын дуунд халдаж ирсэн түүхтэй юм. Учир нь манай уртын дуу нь талбуун тайван аятай аялгууны өсөлт нь огторгуйгаас тасрах шиг аталаа эргээд уул усандаа шивнээд ирэх шиг эх орноо хайрлахын сэтгэлийг хөвөлзүүлдэг. Энэ чанараасаа болж Манж чин улсын үед ч буддын шашин анх дэлгэрсэн цагаас ч ардын хувьсгал үүссэн үед ч нүд үзүүрлэгдэж ирсэн нь түүхэн үнэн юм. Ялангуяа ардын хувьсгалын эхэн ба дунд үе 1937-1938 онуудад Чингис хааны алтан ураг тайж тавнагийн хүүхдүүд буюу үндэсний сэхээтнүүдийг устгаж эхлэхийн сацуу жанжны клуб үндэсний театр хэмээх бөмбөгөр ногоонд ядуу ардын хүүхэд партизаны хүүхдүүд хувьсгалчдын гэхчилэн ангич үзлээр ялган урлаг соёлын харгис бодол явуулж ард түмний дуучин хүрээний дуучин хөгжимчид бүжигчдыг феодалын Богдын ордонд хөгжимчин дуучин явснаар нь гадуурхах бодлого явуулсан нь шинэ нийгмийн соёлыг нэвтрүүлэхээсээ илүү үндэсний соёлыг устгах үүдийг нээснээс хүрээний гэх соёл урлаг дуу хөгжим бүжиг нь эртний хүн гүрний үүдэлтэй нүүдэлчдийн урлагт хохирол учруулсныг улам өгшүүлсэн Х.Чойбалсангийн шийдвэрээр 35-урт богино дууг эсэргүүний дуу феодалын дуу хэмээн ангилж дуулахгүй байх устгах тогтоол гарсны дээр тухайн үедээ нэр алдар эрдэм номгүй хөвсөргөн хөөрүү ядуу хүмүүсийг сонгож төр барих эртний уламжлалт ёс дэг журмыг устгаж Марксист арга онолд тулгуурлан бэлтгэхдээ

үндэсний урлаг соёлд өширхөж гуйвуулагчид болон ихэнх нь хувирч Монголын соёл урлагт нөхөгдөшгүй гарз тотгор учруулсан юм.

Миний бие 1960 оноос 1966 оны хооронд Хэнтий аймгийн Гал шар сум болон Мөрөн суманд малын эмчээр ажиллаж баг бригад малчны суурь айл өрх бүрт орж малчидтай уулзаж үе үе аймаг явж ажлынхаа заваар амралтаараа Дадал, Бат ширээт Баян-Адрага, Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Цэнхэр, Баянхутаг, Өмнөговь аймгийн Алтан ширээ, Их Хэт сум хүртэл явж найз танил нөхдөөрөө дамжуулан тэр үеийн номтой бичигтэй хууч хөөрч үлгэр домог үүх түүх дуу урлаг мэддэг гэсэн 70-аас дээш насны өвгөд, хөгшидтэй уулзаж одоо амны уншлага болсон Чингис хаантай холбоотой газар нутаг хиргисүүр булш хөшөө чулуу үзэж Бэрээвэн хийдээс гадна хэд хэдэн хийдийн туйр үзэж Цэвээн тайжийг дагаж Бароны цэрэгт явсан Гэндэн хэмээх өвгөн, харчин Бавуужавын морин улаач явсан хуухуй хэмээх Наваан VIII Богдын бага хатан Гэндэнпэлийн аячин хундагачин яван Пүрэвдулам гоймоны цэрэгт булаагдан оргож зугтаж ирсэн. Сөнөддийн Цэцэгдарь хатан Халхын сайн эрийн тоосонд хутгалдаж явсан Шөвөг хэмээх Пунцаг халхын баян Цэнд зайсан өвгөн лам өнөмөр хаван Онон мөр тайж, өвгөн ноён, жаал ноёны тухай олон үлгэр домог хуучь сонсож явсны эцэст хотод ирж мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнд туслах ажилтай болж доктор Чадраабал, Цэрэндорж, Дашгүнсэн төрийн шагналт доктор Дашдаваа нарын туслах хэмээн Сэлэнгэ аймаг Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Дундговь, Өмнөговь аймгуудаар 45 хоногоос 2 сар хүртэл хугацаагаар явахдаа өнөө л дур сонирхолтой ажлаа хийж олон домогт дуу, ардын дуу, үлгэр хуучь сонсож явсан хэдий ч 1970-аад оны эхээр VIII Богдыг залж ирэхийг үзсэн ойрхоноос сонссон. 1911 оны тусгаар тогтнол Гоймон, Бароны цэрэг хүрээнд орж ирсэн Ардын намын цэрэг хүрээг чөлөөлөх хиагтыг чөлөөлсөн тухай хамтрал комун нугалаа завхрал халх голын дайнд оролцсон хүмүүс нэгдэл нийгэм үүссэн үүх түүхийн амьд гэрч болсон өвгөд Мөнх бусыг үзсэний дээр жинхэнэ мэддэг улс нь 80 хол гарсан, чих нь муудаж ой ухаан нь будилдаг болсны дээр эрдэмтэн хэмээх зарим хүмүүс нь үлгэр домог үүх түүх хууч яриаг нийгмийн аяс цаг үе гэдэг нэрээр өөрчлөн засаж хэвлүүлдэг байсныг нь мэдсэнээс хойш ой гутаж тэдэнтэй муудалцаж олон цуглуулгаа алдаж хавчигдаж эхэлснээ хэлэхэд буруудах юу билээ.

**Домог өгүүлэхэд:** Ардын хувьсгал байгуулагдсаны хойно Сэлэнгэ аймгийн анхны дарга явсан Загхирагжав хэмээх Өвгөнтэй Гал шар суманд ажиллаж

байхдаа 1961 онд уулзахад 80 хол гарсан хирнээ ухаан саруул энэ өвгөнийг аймгийн дарга явах үед Бумцэнд гуай Бухарын зовудын дарга Цагаан эргийн баазын дарга байж байгаад дэвшиж бага хурлын дарга болж ирсэн манай Бум хурандаа гээд л ярьдаг өвгөн байж билээ. Захирагчжав гуай VIII Богдыг их магтдаг хүнсэн. Тэр үед Богдыг бид чинь сохор тэмбүүтэй муу хүн гэж ойлголттой явдаг байснаас өвгөнтэй маргалдах үе гарахад өвгөн муу мод толгойгоо үе үе шийдэж алдас болно. Өмнөх VII Богд чинь харин Монголд элэг тааруу хүн байсан гэдэг. Харин VIII Богд минь тийм хүн биш чи Богдын байгуулсан ан амьтдынхан үзэсгэлэн тэр олон төрлийн усны шувууд ан амьтан зааныг нь үзсэн болоосой чиний тэр асууж байсан эртний сайхан хэмээх дууг чинь VIII Богдын үед л дуулуулдаг болж, Цэцэн хааны мөр Рэнчин аврагаар торгон цэрэгтээ энэ дууг заалгаж гэнээ гэж би дуулдсан юм гэж билээ.

**Хууч сөхөхөд:** Тийм ээ миний таньдаг нэгэн түүхч мөр Рэнчин аврага эртний сайхан дууг овоо тахилга хошуудын найр хуриманд дуулж Богдын торгон цэрэгт зааж байсан байна лээ гэж билээ. Тэгэхлээр захирагч Жав гуайн хэлсэн үнэн байх нь эртний сайхан хэмээх дууг хамаагүй хүн дуулдаггүй төрийн их дуу байж. Ялангуяа эмэгтэй хүн дуулдаггүй байж өвгөн ноёны найранд ногоон Доной хэмээх халхын сайн эр (тэр нутгийн хүн) өвөрлөгч хошуунаас авгайгаа болгон дагуулж ирсэн сайхан сумъяа хэмээх эмэгтэй эртний сайхныг дуулахад ихэс дээдэс ноёд тайж нар харц гаралтай харын эмэгтэй хаяа хатавчнаас хаан эзний дууг дууллаа гэж ихэд зэвүүцэж байсан тухай өвгөдүүд хуучилдаг байлаа.

1990 оны эхээр уртын дууч Ардын жижигчин Шархүүхэнээр эртний сайхныг дуулуулах гэж Монголын үндэсний телевиз авчирхад дуучин Шархүүхэн би дуулж болох юм уу эмэгтэй хүн дуулдаггүй их хүндэтгэлийн дуу гэсэн. Дамчаа багш Дорждавга багшийн үгээр дуулъя гэж хэлээд дуулсан байдаг. 1936 онд анх хэвлүүлсэн алдарт дуучин Магсар хурцын хүү Дугаржав гуай уртын дууны түүвэрт эртний сайхан дууг оруулсан хэдий ч ид уртын болон ардын дууг эсэргүүн феодалын дуу хэмээх хаах тогтоол гарч байсан үе давхцаж ирснээс болж их засагдсан болов уу гэж боддог. Учир нь Улсын гавъяат жүжигчин уртын дууч Дорждавга гуай нэгэн удаа олон урт богины дууг авч үлдэх гэсэндээ би засаж дуулдаг байсан гэж ам алдсан нь үнэний хувьтай. Дээрээс шахаж байсныг үгүйсгэх аргагүйч өөртөө засааж дуулах мэдэмгийрэх сонирхолтой хүмүүс байсныг ч үгүйсгэх аргагүй. Дуучин Магсар хурцын Дугаржав болон уртын дууч Улсын

гавъяат жүжигчин Дорждавга гуайн эмхтгэсэн уртын дуу хэмээх номуудад орсон. Эртний сайхан дууны үгийг утга зохиол, урлаг судлаач, эрдэмтэн доктор Х.Сампэлдэндэв аман зохиол хэмээх номондоо хуулбарлан оруулсныг Ардын жүжигчин уртын дууч Шархүүхэн дуулсан дууны үг нь:

Эртний сайхан ерөөлөөр

Энэ сайхан оронд

Эзэн Чингис хааны

Залуу баатруудын туг мандав аа гэж ийм үгээр ганцхан Шархүүхэн ч дуулсан ч биш Дорждавга, Дамчаа зэрэг олон хүн дуулсан нь радиогийн фонтод байна лээ. Ардын хувьсгал байгуулагдсаны дараа цэргийн баяр гэж Ардын хувьсгалын баярыг тэмдэглэж байх үед Амар бэйс эртний сайхан дууг дуулж чаддаг хүн олж наадмыг эхлүүл гэснээс тэр үеийн цэргийн наадам бага үд хүртэл хойшилсон тухай хөгшчүүд ярьдаг. Тэгэхээр эртний сайхан дуу бол зүгээр нэгэн дуу биш монгол үндэстний сэргэн бадрахын бэлэгдэл туг нь болж ирсний шинж гэлтэй.

**Түүх шастирын хуудас сөхөхөд:** Зохиолч Ч.Адъяасүрэн, Х.Нямбуу. Монгол ёс заншлын тайлбар толь I. 158-159 дүгээр хуудас. Чингисийн төрийн дуулал. Эртний сайхан гэдэг дуу бол эрт дээр үеэс уламжлагдаж ирсэн Чингисийн төрийн дуулал буюу сүлд дуу хэмээн ихэд хүндлэж иржээ. 1930-иад оны сүүлчээр эртний сайхныг дуулахаа болж өдүгээ мартагдахад хүрчээ. Харин 1936 онд алдарт дуучин агсан Магсар хурцын Дугаржав Монгол ардын уртын дууны түүвэрт оруулж хэвлэсэн нь өнөө хүрч ирсэн байна. Мөн Улсын гавъяат жүжигчин Жагзавын Дорждавга гуай 1970 онд эмхэтгэн хэвлүүлсэн уртын дуу хэмээх номондоо оруулсан боловч үг нь их өөрчлөгджээ. Ер нь Монгол ардын богино дуу ялангуяа уртын дуунууд цаг үеэ дагаж үг нь өөрчлөгдөж ирсэн байдаг. Ийм өөрчлөлтүүд нь Шарын шашин ихэд түгэн дэлгэрч байсан үе тухайлбал XIX-XX зууны эхэн үеийн уртын дуунд нилээд түгээмэл ажиглагддаг. Жишээ нь: XIII Далай лам Түвдэнжамц 1904 онд Монголд ирэхэд

Ванчин далай ламдаа

Бараа болон жаргая гэж эртний сайхан дууг төгсгөдөг бол 1911 онд Монголчууд манжийн дарлалаас гарч тусгаар улсыг байгуулж Богд Жавзундамбыг шашин төрийг хослон баригч хэмжээгүй эрхт хаанд өргөмжилсөн үеэс эртний сайхан дууны үгэнд өөрчлөлт орж

Хаан эзэн Чингисийн авралаар

Хамаг Монголын эзэн бид

Хаан сүлд тугийн өмнө

Хамт бүгдээрээ биширэн жаргая гэж дуулдаг байсныг тэмдэглэсэн байна. Улсын гавъяат жүжигчин Дорждавгийн шавь Түвшинжаргалын дуулсан радио телевизд бичүүлсэн одоо дуулж байгаа эртний сайхан хэмээх дуу бол Очирдарь богд лам Ванчин ламдаа бараа болж жаргая, VIII Богдыг хэмжээгүй эрхт хаанаар сонгоход зориулсан. Хаан сүлд тугны өмнө хамт бүгдээрээ бишрэн жаргая, Сүмбэр уул тэгш таван хүсэл хэмээх дууны цуглуулгыг эртний сайхан дууны малгай өмсгөж засагдсан олон хуйлбарыг бөөндөж дуулсан үг гэхээр байдгийг нуух нь юу билээ.

### Эртний сайхан

(Чингисийн төрийн дуулал)

Эртний сайхан ерөөлөөр

Энэ сайхан оронд нь

Эзэн Чингис хааныхаа

Язгууран ээц бүрдэв ээ хө

Тэнгэр мэт заяатай

Тэгш таван оюунтай

Тэнүүн уужим зарлигтай

Тэнгэрийн минь үр сад билээ

Олон одны дундаас

Сарны гэрэл тодорхой

Олон хүмүүний дундаас

Яндар мэт чимэгтэй

Сүмбэр уулын оройгоос

Сүндэрлэж цацраад

Сүр Жавхлан дэлгэрээд

Сүлд нь бат болтугай

Хамаг номын рашааныг

Ханахуй чинээгээр хүртээд

Хаан эзэн Чингисийн өмнө

Хамаг бүгдээрээ жаргая хэмээн Монгол ёс заншлын их тайлбар толь I. 159-160 хуудаст тэмдэглэжээ. Сүүлийн үед зарим нэгэн эрдэмтэд ялангуяа хэл утга зохиолын хүрээлэнгийн захирал эрдэмтэн доктор Х.Сампэлдэндэв эртний сайхан дуу бол Чингис хааныг амьд ахуйд зохиогдсон дуу хэмээн Улаанбаатар телевизээр зохиомжит нэвтрүүлэг хийгдсэн нь уг дууг Чингис хааныг амьд сэрүүн ахуйд зохиогдсон гэх хүмүүс нилээд байдаг энэ нь юу бол.

**Хууч сөхөхөд:** Эрт дээр үед ямар улсын эзэн хаан байлаа ч эрх мэдэл, эд хөрөнгө нэр төрдөө ташуурч үхэхгүй юм шиг эндүүрч үүрдийн юм шиг эрдэж бардаж өөрийгөө ерөөлөөр магтуулж дуу шүлэг зохиолгож байсан нь гэм биш зан бололтой юм билээ. Саяхан хүртэл бид чинь

Эрэлхэг Монголын ард түмэндээ

Чимэг болон хайрлагдсан Чойбалсан

Таны гавъяа зүтгэлээр

Азийн цээжинд Их улсыг байгуулав гээд л дуулж байлаа. Ганц энэ ч биш залуу жанжин Лхагвасүрэн Цэдэнбал дарга /энэ дууг 1953-4-5 онуудад хэсэгхэн дуулаад Цэдэнбал дарга өөрөө зогсоо гэсэн үг бий. Энэ мэт дууны хажуугаар Ленин багш Сталин, Варшилов Моо Цедүн Кимерсэн тандаа гэх мэт урт дууны жагсаалт хөвөрнө дөө, тэгэхээр саяхан ийм л байсан юм чинь тэртээ найман зуун жилийн өмнө дуу зохиосон байж л таарна гэж түүхийг гөрдөж гүтгэж болохгүй.

**Түүхийн хуудас сөхөхөд:** Хаан хөвгүүдээ элдэв нэгэн чимэг хоосон алдарт бүү шунаж яв ганцхан хаан гэдэг нэрээ хамгаалж яв гэж захисан тухай бичих боллоо. Тэгэхлээр энэ үнэн бол Чингис хааныг амьд сэрүүнд эртний сайхан дууг зохиогоогүй нь лав учир нь хаан эцгийгээ дуурайж Өгөөдэй Гюуг Мөнх хубилай нар дуу зохиолгох биш үү. Хаан эзний минь хаан, хөвгүүд өөрсдөө дургүй байлаа ч хаанд тал засагчид байдаг хойно дуу зохиож таарна. Зохиосон бол түүхийн олон сурвалж бичигт тэмдэглэгдсэн байж таарна тийм бол эрт орой нэгэн цагт гарч ирэхийг нь хүлээх л болж. Энэ эртний сайхан дууг өчүүхэн миний бие Өгөөдэй хааны дараа хаан ширээнд суусан Гюүг хааны үеийн төрийн хямрал хааны эх Дөргөн хатныг төр барьж байх үед гарсан ах дүүгийн хооронд гарсан зөрчил маргаан, хэрүүл тэмцэл, хов живээс болж эв эвдэрхийг харах ч үгүй хүсэх ч үгүй Чингис хааныг амьд сэрүүнд нь алба хашиж чин сэтгэлээсээ нөхөрлөж явсан нөхөд нь энэ дууг зохиосон байж таарна. Учир нь Мөнх хааныг хаан ширээнд

суухад анх зохиогдож дуулагдсан болов уу яагаад юу юунаас илүүтэй эв нэгдлийг эрхэм жаргалд тооцох болов тэр үед эзэн хааны суурины төлөө тэмцэлдсэн хямралын энэ үед юу сануулж юугаар бахархах юу хэрэгтэйг энэ дуунд юу гэж өгүүлсэнийг харъяа 1960 оны үед хардал жанжин бэйсийн хошуу одоогийн Гал шар сумын харъяат өвгөн ноёны ач Пунцагнамжилын хүү гүний Гомбосүрэн гуайгаас анх тэмдэглэж авсан эртний сайхан хэмээх үгийг толилуулъя.

### Эртний сайхан

Эртний сайхан ерөөлөөр

Энэ Монгол орондоо

Эзэн Чингис хааны үрс нь болж

Хувьтайхан төрсөн ах дүү та нар минь уу зээ

Мөнх хөх тэнгэрийн доор

Монгол эх орондоо

Мөхөшгүй суут Чингис хааны үрс нь болж

Хувьтайхан төрсөн ах дүү та нар минь уу зээ

Эртний ерөөлөөр төрсөн

Энэ Монгол орондоо

Эзэн Чингис хааны үрс нь болсон бид

Эндэлгүй жаргахын ерөөл тавъяа ах дүү та нар минь уу зээ гэж дуулдаг энэ дууны үгийг надад хэлж бичүүлж дуулж өөрөө хуурдаж өгсөн. Гүний Гомбосүрэн гуай минь гайхалтай хуурддаг хүн байж билээ. Өвгөн ноёны ач Пунцагнамжил гүний хүү болж төрсөндөө л Гомбосүрэн гуай минь нэгдэлд мал өгч нийгэмчлэх үүрэгтэй ч нэгдэлдээ ажиллах эрхгүй гайхалтай сайхан морин хуур тоглож эвлэгхэн дуулдаг хирнээ урлаг уран сайхны концерт нь оролцох ёсгүй нэгэн явж ангич намч үзэл суртлын мугуй үзэлд хавчигдсан нэгэн байж билээ. 1964 онд Мөрөн сумын малын эмч шар Гомбо хэмээх энэ дууг концертонд дуулуулж аймагт тоглуулсан хэргээр аймгийн намын хорооны 1 дүгээр дарга Б.Цэрэннадмид даргын сүргийг үзэж шоронд орохын наана аймгийн дарга Хавдал, Мөрөн сумын намын үүрийн дарга Сүрэнжамц хоёрын хүчинд Гомбо гуай бид хоёр шоронд оролгүй ажил дээрээ дээсэн дөрөөтэй тогтож билээ. Тэрнээс хойш эртний сайхан дууны үгийг нууц дарж явсаар 1990 олны эхээр засгийн газрын сонинд зохиолч Батсайхан хэмээх тавьж өгсний дараа уртын дууч Дэлгэр дуулж радиогийн

фонтонд бичүүлсэн бий. Ингэж үйл тамаа үзэх шахаж хаан эзнийхээ дууг олж тэмдэглэсэн минь энэ болой. Монголчууд бидэнд эв нэгдэл хамгаас үнэтэй энэ үед эртний сайхан хэмээх энэ гайхамшигт дууны сүүлчийн бадагаар уул дууны домогоо өндөрлөө.

Эртний ерөөлөөр төрсөн

Энэ Монгол орондоо

Эзэн Чингис хааны үрс нь болсон бид

Эндэлгүй жаргахын ерөөл тавъя ах дүү та нар минь үү зээ.